

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 он

АГУУЛГА

- 1. НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**
- 2. НЭГЖИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 3. БАЙГУУЛЛАГЫН АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР**
- 4. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР**
- 5. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР**
- 6. АРХИВЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР**
- 7. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**
- 8. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**
- 9. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**
- 10. САНХҮҮ БҮРТГЭЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР**
- 11. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР**

НЭГ. НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус хэлтэс нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, урт дунд хугацааны бодлогын баримт бичгүүд, үндэсний хөтөлбөр, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, бусад дэд төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлт, Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиуд, улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан багц хууль, холбогдох журмуудын хэрэгжилтийг тус тус хангахад чиглэн ажиллалаа.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Аргачлал загвар батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг үндэслэн “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан, арга хэмжээний шалгуур үзүүлэлт бүрийг тодорхой хугацаанд биелэгдэхээр төлөвлөн боловсруулж, тогтоосон хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж батлуулсан.

2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилт, 25 арга хэмжээ 38 арга хэмжээний хүрээнд боловсруулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар, нэгжийн төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтсийн даргаар тус тус хянаж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ХОЁР. НЭГЖИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангаж, бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь гэр бүлийн бяцхан гишүүдийн хамтаар 150 ширхэг хайлаас модыг байгууллагынхаа гадна талбайд шинээр тарив. Мөн өмнө тарьсан мод бутынхаа 10%-ийг нөхөн тарьж, засч хэлбэржүүлэлт хийн арчилж, хаврын цэнэг усалгааг хийж гүйцэтгэлээ.



2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилсан “ХАМГИЙН ЧУХАЛ НЬ” эрүүл мэндийн зорилтот аяны 7-р ээлж 2025.05.17-2025.05.19-ний өдрүүдэд тус

аймагт ажиллаж, амьдарч байгаа ХЗДХЯ-ны харьяа агентлаг байгууллагуудын ажилтан алба хаагч, тэдний гэр бүлийнхний өвчлөлийг эрт оношлох, халдварт бус өвчний эрсдлийг тодорхойлох, тандалт хийх, эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан. Тус үзлэгт хэлтсийн 25 албан хаагч тэдний гэр бүлийн насанд хүрсэн 1 гишүүнийг оролцуулаад нийт 46 хүнийг үзлэг, шинжилгээнд хамрагдууллаа.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөн”-ийг улсын хэмжээнд идэвхитэй амьдралын хэвшлийг дэмжих аяны хүрээнд “Илүүдэл жингүй эртэч Сүхбаатарчууд” уриан дор бүх нийтийн гүйлтийг хуваарьт өдрөө буюу 2025.05.17-ны Бямба гарагийн өглөө 7:00 цагт Сүхбаатарын талбайд хамтран зохион байгууллаа. Гүйлтийн үеэр салбар дундын хамтын оролцоог нэмэгдүүлэх, иргэд олон нийтийг биеийн тамир спортоор хичээллэхийг уриалах, оролцогчид витаминжуулалт хийх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах зэрэг албан хаагчдыгаа эрүүл мэндэд анхаарах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Тус үйл ажиллагааг Биеийн тамир спортын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, 3-р цэцэрлэг, Хас банк зэрэг албан байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.




4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах төлөвлөгөөг боловсруулж хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан онцлох ажлуудаас дурьдвал:


- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэхдээ дараалалгүйгээр, тусгайлан үзүүлж, зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж хэвшсэн төдийгүй харааны шил байршуулж өгсөн.
- ✓ ХЗДХЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлөөс ирүүлсэн албан даалгавар болох “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ийн конвенцийн зөвлөмж”-ийг сурталчлах, хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх нөлөөллийн сургалтыг өгөх зорилгоор “Тусч хүч” ТББ-ийн тэргүүн С.Эрдэнэбат, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн Өндөр настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн С.Балжинням нартай хамтран албан хаагчдад мэдээлэл өгөх уулзалтыг зохион байгуулсан..



✓ 2025 онд хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай нийт 8 иргэнд гэрээр очин улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмуудын нэг болох “хүнлэг энэрэнгүй байх” зарчим болон нийтлэг хэм хэмжээнд нийцүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн үйлчилгээ авах, хүртээмжтэй байх, саадгүй нэвтрэх эрхийг хангах үүргээ биелүүлж, нийтийн ашиг сонирхлыг хангах зорилгоор байгууллагын 1 дүгээр давхарт тусгайлан өрөө гарган, тэргэнцэртэй иргэн саадгүй нэвтрэх боломжоор ханган засварлаж, улмаар “ӨНДӨР НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ ӨРӨӨ” болгон тохижуулсан. Энэ арга хэмжээг авч хэрэгжүүлснийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд туйлын талархалтай хүлээн авч улмаар 1111 төвд талархал ирүүлсэн байна.






✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй нэвтрэх боломжийг бүрдүүлэн байгууллагын гадна талбайд налуу зам болон тус иргэдийн авто машин зогсох зогсоолыг хийж тэмдэг тэмдэглэгээг хийв.



5. Төрийн үйлчилгээг иргэдэд тав тухтай орчинд үзүүлэх, мөн ажилтан албан хаагчдыг хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлд ажиллуулах зорилгоор өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан хэлтсийн иргэдийг угтах хэсгийг засч тохижуулав.



6. Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85, Бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 16 жилийн ой, “Улсын бүртгэлийн ажилтны өдөр”-ийг угтан Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2025 оны УБЕГ-ын төлөвлөгөөний дагуу байгууллагын дотоод соёлд ёс зүйн үнэт зүйлийг төлөвшүүлэх, ажлын орчинд харилцан хүндлэл, шударга ёсыг дэмждэг хамт олныг нийтэд таниулах зорилгоор улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмыг баримталдаг, удирдлага, хамт олны уур амьсгал эерэг, харилцаа хандлагадаа анхаардаг “Ёс зүйтэй хамт олон”-ыг шалгаруулах удирдамжийн дагуу тус хэлтэс “Ёс зүйг эрхэмлэх сар” аяны хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Тус төлөвлөгөөний дагуу Төрийн үйлчилгээний гавъяат ажилтан Б.Сүхбаатарыг урьж “ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ” сэдэвт сургалт уулзалтыг зохион байгууллаа. Сургалтын хүрээнд “БИД ЁС ЗҮЙТЭЙ АЛБАН ХААГЧ ” тангаргын хуудаст ёс зүйг эрхэмлэн дээдлэхээ илэрхийлэн гарын үсэг зурж баталгаажууллаа.

Мөн хэлтсийн дарга Ц.Мөнхчимэг албан хаагчдад танхимаар болон цахимаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийг сурталчилж сургалт мэдээлэл өгч, нөлөөллийн ажлуудыг зохион байгууллаа.



7.Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран 2 иргэний гэрлэлтийг бүртгэлийг хорих ангид нь очиж бүртгэсэн.

8. Монгол улсын Засгийн газраас дэвшүүлж буй төсвийн зардлыг багасгах, бүтээмж муутай орон тоог цөөлөх, бусдаар гүйцэтгүүлж болох чиг үүргийг төрийн бус байгууллага, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж төсвийг хэмнэх зорилгын хүрээнд харуул, дохиолол хамгаалалтын “Классик сити” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж 2025 оны 07 дугаар сарын 30-31-ны өдрүүдэд дээрх ХХК тус хэлтэст ирж ажиллан Pima брэндийн 18ш хөдөлгөөн мэдрэгч, 10ш утааны мэдрэгч, 2ш усны мэдрэгч зэрэг төхөөрөмжүүдийг суурьлуулж 2025 оны 08 дугаар сарын 01-ны өдрөөс харуул хамгаалалтын хэвийн байдалд шилжин ажиллаж байна

9. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2-д заасны дагуу тус хэлтэст эмнэлгийн онош С-24.1 заалтаар хөдөлмөрийн чадвараа 70 хувь алдсан албан хаагч ажилладаг.

10. Тус хэлтсийн Түмэнцогт сумын бүртгэгчийн хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд ар гэрийн асаргаанд байдаг тухайн албан хаагчдад гэрээсээ, зайнаас, бүтэн бус цагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг бий болгон ажиллаж байна.

11. "Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж мөн 2025 оны 05 сарын 19-ны өдөр биелэлтийг УБЕГазарт хүргүүлсэн бөгөөд тус хэлтсийн 30 албан хаагчдаас Жендерийн үндэсний хорооны "Иргэд олон нийтэд зориулсан жендерийн цахим тест"-д 3 албан хаагч хамрагдаж гэрчилгээг аваад байна.

12. Олон улсын ахмадын баярын өдрийг тохиолдуулан салбартаа олон жил ажиллан, үнэтэй хувь нэмэр оруулсан ахмад ажилтнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.



ГУРАВ. 3. БАЙГУУЛЛАГЫН АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тус хэлтсийн бичиг хэрэг 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 14 зорилтын арга хэмжээг төлөвлөн хэлтсийн даргаар батлуулж ажиллаа. Төлөвлөгөөний биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй биелэгдсэн.

2025 оны 11 сарын байдлаар ERP программаар дамжуулан дээд газар болон бусад агентлаг албадаас 508 албан бичгийг хүлээн авч бүртгэл хөтлөн албан хэрэг хөтлөлтийн программд хариуцсан албан хаагчид руу шилжүүлж хариу хүргүүлэх шаардлагатай 293 албан бичиг хариу хүргүүлж, 365 албан бичгийг цахим системээр дамжуулж илгээсэн байна.

Ирсэн явуулсан албан бичгийг цахим хэлбэрээр мөн хавтас үүсгэн хадгалж цахим баримтын хадгаламжийн нэгжийг үүсгэн ажиллаж байна.

Өргөдөл гомдлын мэдээг сар, улирлын мэдээг гарган УБЕГ руу илгээж ажиллаж байна. Хугацаа хоцроосон буруу зөрүүтэй гаргасан мэдээлэл байхгүй болно. 2025

он гарсаар албан хаагчид болон аж ахуй нэгж, иргэнээс нийт 14 өргөдлийг хүлээн авч бүртгэн хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлсэн байна.

Хэлтсийн даргын зөвлөл болон хамт олны нийт 9 удаагийн хурлыг тэмдэглэл хөтөлж бүртгэн баталгаажуулсан.

16 албан хаагчийн давхардсан тоогоор 45 гаруй чөлөөний хуудсыг бүртгэн хөтөлж хэлтсийн даргаар батлуулан чөлөө зөвшөөрлийг бүртгэсэн.

Хэлтсийн даргын боловсон хүчний болон үйл ажиллагаанд хамаарах нийт 39 тушаалыг бүртгэн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хэвлэмэл хуудсанд буулган баталгаажуулж тушаалын хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын дагуу 2025 оны 01 дүгээр сараас эхлэн албан хэрэг хөтлөлтийг крилл болон үндэсний хос эгшигээр хослуулан бичихтэй холбогдуулан тус хэлтэс нь 2025 оны 01 дүгээр сараас эхлэн албан бичиг, болон захирамжлалын бичгийг крилл болон хос бичгээр хослуулан бичиж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн Монгол Улсын ерөнхийлөгчийн тамгын газрын дэргэдэх Хэлний бодлогын 5 гишүүн Сүхбаатар аймагт 2025 оны 04 сард ирж ажиллан 5 агентлаг албадыг түүвэрлэн шалгах удирдамжийн дагуу тус хэлтэс шалгагдаж дээрх хуулийн хэрэгжилт болон хос бичгээр бичих шалгуур үзүүлэлт хэрхэн бичиж байгаа эсэхэд хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулсан. Үүнд тус хэлтэс хангалттай сайн үнэлэгдсэн.

Тус хэлтсийн архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав Г.Болор-Эрдэнэ нь 2025 оны 3 дугаар улирлыг архив албан хэрэг хөтлөлтийг улсын үзлэг 2025 оны 3 дугаар улиралд зохион байгуулахтай холбоотойгоор дараах арга хэмжээг хяналтандаа авч ажиллаа. Үүнд:

Монгол улсын засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 23 дугаар тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны А/153 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх урьдчилсан үзлэг явуулах төлөвлөгөө”, улсын үзлэгийн шалгуур үзүүлэлт болох:

- Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг дүгнэх шалгуур үзүүлэлт
- Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг дүгнэх шалгуур үзүүлэлт
- Байгууллагын архивын үйл ажиллагааг дүгнэх шалгуур үзүүлэлт тус бүрээр биелэлтийг гарган тайлагнан ажиллаа.

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/435 тоот захирамжаар Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны түвшинг тогтоох улсын үзлэгийн бэлтгэл хангуулах, удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсаны дагуу аймгийн Төрийн архивын тасгаас 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр хуваарийн дагуу ирж шалгалаа.

Дээрх шалгалтанд байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн 3 шалгуур үзүүлэлтийн дагуу нэг бүрчлэн шалгасан.

Архивын хэлтсийн дарга дээрх үзлэг шалгалтанд тус хэлтсийг бүрдүүлэх бичиг баримтыг шалгуур үзүүлэлтийн дагуу сайн бэлдсэн байна гэж дүгнэлээ.



Мөн бүх албан хаагчдаас архив, албан хэрэг хөтлөлтийн наад захын мэдлэгийг шалгах сорил авлаа.



Хэлтсийн даргын 2025.01.06-ны өдрийн А/02 тоот тушаалаар улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг 7 гишүүнтэйгээр байгуулж ажлын хэсгийн удирдамж гарган 2009-2024 оны баримтад нэг бүрчлэн нягтлан шалгалт хийж нийт 2009-2024 оны 180 гаруй баримтыг ангилж цэгцэлж янзалсан.

Хэлтсийн даргын 2025 оны А/12 дугаар тушаалаар Байгууллагын хадгаламжийн нэгжийн бодит тоог тогтоох, тоо бүртгэлийн баримт бичигтэй тусгагдсан тоотой тохирч буй эсэхийг шалгах, миханик болон биологийн гэмтлээс урьдчилан сэргийлэх, сэлбэн засах шаардлагатай баримтыг илрүүлэх зорилгоор архивын баримтад тооллого явуулах комиссыг байгуулсан. Дээрх комисс байгууллагын архивыг тоолох ажлын хэсгийн удирдамжийг боловсруулан байгууллагын 2009-2024 оны баримтыг нэг бүрчлэг тоолох ажлыг зохион байгуулж ажиллаа.

Байнга хадгалах 137, түр хадгалах 125, 70 жил хадгалах 41 баримтыг тоолох ажлыг зохион байгуулж ажилласан.



Байгууллагын архивт нийт 303 баримтыг тоолж дуусгасан Түр хадгалах 125 баримтаас хадгалах хугацаа дууссан 67 баримтыг устгахаар акт үйлдэн хэлтсийн даргад танилцуулж устгах хэргийн актыг батлуулсан.

Байгууллагын архивын ажилтан үлгэрчилсэн жагсаалтын дагуу зохион байгууллалтын нэгж ажилтан болох нягтлан бодогч, хяналтын улсын байцаагч нараас удирдлагын түвшинд үүсч хөтлөгддөг баримтуудыг ХХНЖ-ын дагуу эмхлэн цэгцлүүлж архивт шилжүүлэн ажиллаж байна. Хяналтын улсын байцаагчаас 2024 онд хөтлөгдөж дууссан 30 ХН-ийн 2309 хуудас бүхий баримтыг, нягтлан бодогчоос санхүүгийн холбогдолтой 11 төрлийн баримт бичгийг актаар хүлээн авч ХН нэгж үүсгэсэн.

Мөн 2009-2024 оны баримтад нэг бүрчлэн нягтлан шалгалт хийж нийт 2009-2024 оны 180 гаруй баримтыг ангилж цэгцэлж янзалсан.

Тооллогоор байгууллагын архивт түр хадгалах 125 хадгаламжийн нэгжээс хадгалах хугацаа дууссан эрдэм шинжилгээн ач холбогдолгүй болсон 67 баримтыг түүвэрлэн авч устгахаар БНШК-ын 2025 оны 03 тоот хурлаар хэлэлцүүлж устгалд оруулахад бэлэн болсон байна.

Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулах тоо бүртгэл, эрэл хайлт, ашиглалтын үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгох, эх баримтыг ашиглалтаас чөлөөлөх зорилгоор 2009-2024 оны нийт 59, байнгын 45 баримт нийт 104 баримтыг цахим хэлбэр шилжүүлж цахим мэдээллийн санг үүсгээд байна.

Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу захиргааны шийдвэр бүрд хяналтын дагалдах хуудас хавсаргаж байгаа бөгөөд дагалдах хуудсанд захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагч бүрийн нэр, албан тушаал, оролцоо, тэмдэглэж хэвшсэн.

2025 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 39 тушаалд хяналтын дагалдах хуудсыг бүртгэн хавсаргасан байна.

2009-2024 онуудын захирамжлалын баримт бичгүүдийг хавсралтын хамт он оноор нь хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын индексээр дугаарлан цахим архив үүсгэсэн.

Байгууллагад үүсч хөтлөгддөг баримт бичгийн эргэлтийг мэдээг хагас жилээр гаргаж хэлтсийн даргад танилцуулж хэвшсэн.

Архивын үйл ажиллагааны төлөвлөгөөний 16 дахь заалтанд эрүүл ахуй, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг тусган хортон шавьж устгалын 2025 оны 06 сарын 17-ны өдөр ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг байгууллагын архив болон төрөлжсөн 2 архивт хийж гүйцэтгэсэн.



ДӨРӨВ. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны Сургалтын төлөвлөгөөг хэлтсийн даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлуулан ажиллаа. Батлагдсан хувиарын дагуу албан хаагчдыг сургалтанд хамруулж мөн УБЕГазар болон бусад байгууллагуудаас зохион байгуулагдсан танхимийн болон цахим сургалтуудад албан хаагчдыг хамруулсан. 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар танхимын болон

цахим хосолсон 42 төрлийн сургалтад нийт албан хаагчид хамрагдан суралцаад байна. Онцлог сургалтуудыг дурьдвал.

1.Онцгой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд 2025.04.29-нд Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газраас Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл ашиглах, эрсдэлийг бууруулах чиглэлээр танхимийн болон дадлага сургалтыг хийж ажиллав.



2.KOICA Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгээр хэрэгжүүлж буй “Монгол улсын бүртгэлийн системийн дижитал чадамжийг бэхжүүлэх хөтөлбөр (2023-2025)-ийн 3 дахь ээлжийн сургалтад тус хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Мөнхчимэг нь хамрагдаж, БНСУ-д 14 өдрийн хугацаанд адил чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага болох БНСУ-н Шүүхийн байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, дадлага туршлага хуримтуулан, Монгол улсын бүртгэлийн байгууллагын цаашид авч хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байгаа арга хэмжээг тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг багаар боловсруулалцаж ажиллаа.



3.2025.01.29,30-ны өдрүүдэд АЗДТГ-ын хууль эрхзүйн хэлтсийн архивын тасгаас зохион байгуулсан архив албан хэрэг хөтлөлтийн сертификат олгох төлбөртэй сургалтанд архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав Г.Болор-Эрдэнэ амжилттай хамрагдаж сертификат авсан.



4. 2025.05.09-нд Сүхбаатар аймгийн ЗДТГ, Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт”-нд танхимаар хэлтсийн төвийн болон сумдын 6 -н албан хаагч хамрагдав.



5. УБЕГ-аас зохион байгуулсан шинээр томилогдсон Улсын бүртгэгч нарыг чадавхжуулах, ажлын байрны дадлага сургалтанд Онгон сумын Улсын бүртгэгч Б.Батбилэг, Баяндэлгэр сумын Улсын бүртгэгч Б.Амарсанаа нар 09 сарын 22оос 10 сарын 03ны өдрийг хүртэл хамрагдаж амжилттай төгсөж сертификат гардан авлаа.



6. 2025.10.22-нд Баруун-Урт сумын ЗДТГ, Сүхбаатар аймгийн Соёл урлаг аялал жуулчлал Залуучуудын газар, Сүхбаатар аймгийн Насан туршийн суралцахуйн төв хамтран “Угийн бичиг хөтлөлтийн сургагч багш бэлтгэх” сургалтанд Улсын бүртгэгч Б.Алтанзул хамрагдаж сертификат авсан.



7. 2025.02.20-нд “ЭХЭУБ болон ХЭЭУБүртгэлтэй холбоотой цахим болон ажлын байрны дадлага сургалтыг ЭХЭУБүртгэгч Г.Оюунжаргал, ХЭЭУБүртгэгч Ж.Должинсүрэн нар зохион байгуулсан.



8. Албан хаагчдыг монгол бичгийн чадвар эзэмшүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Удирдлагын академийн сургалтын нэгдсэн платформ (<https://surgalt.gov.mn>)-д байршуулсаны цахим хичээлүүдийг албан хаагчдаар үзэж, судлуулан

ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

1. Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэсийн хяналтын улсын байцаагч Б.Одонзул миний бие Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2025 оны нэгдүгээр улиралд Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, тэлэх, улмаар сумдын улсын бүртгэгчдэд эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх олгогдсонтой холбоотойгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг шинээр 7 суманд хүргэж эхэлсэн бөгөөд эдгээр сумдын бүртгэлийн үйл ажиллагаа болон хэлтсийн хэмжээнд хийгдсэн нийт бүртгэлд хяналт тавин ажиллаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл: Тус сумд нь 2025 оны нэг дүгээр улиралд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 168 ширхэг бүртгэл хөтөлсөн байх бөгөөд тус бүртгэлийн 72 ширхэг бүртгэлд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтын явцад 9 бүртгэлд зөрчил илэрсэн байх бөгөөд

- ✓ 2 бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн №1348 тоот дүгнэлтээр зөрчилийг арилгуулав.
- ✓ 6 бүртгэлийн зөрчилийг хяналт шалгалтын явцад алдааг залруулав
- ✓ 1 бүртгэл барьцааны гэрээнд бүртгэлтэй байх бөгөөд барьцааны гэрээ дуусгавар болмогц хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр зөрчилийг арилгах.

Хяналт шалгалттай холбоотойгоор нийтлэг илэрч буй зөрчил болон цаашид бүртгэл хөтлөх тал дээр анхаарвал зохих асуудлуудаар хэлтэсийн болон сумдын улсын бүртгэгч нарт сургалт зөвлөгөөг өгч ажиллав.

Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт хийгдсэн бүртгэлийн 70 гаруй хувьд хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтын явцад нийтлэг илэрч буй засаж болохуйц зөрчилийг газар дээр нь арилгуулан ажиллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл: Шинээр хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэл хөтлөж байгаа сумдын бүртгэгч нар нэгдүгээр улиралд 97 бүртгэл хөтөлсөн байх бөгөөд

- ✓ Төрийн бус байгууллагын тайлан-34
- ✓ Мэдээлэлд оруулсан өөрчлөлт -21
- ✓ Лавлагаа-1
- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлд шинээр бүртгүүлэх -39
- ✓ Татан буулгах хүсэлт -2 бүртгэгдсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн сумдын 97 бүртгэлээс 97 бүртгэлийг шалгасан бөгөөд 2 зөрчил илэрсэнийг хяналт шалгалтын явцад залруулан ажиллаа.

2025 онд хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн татан буугдсан 7, эцсийн өмчлөгчийн мэдээлэлээ бүртгүүлэх 21, салбарын бүртгэл 10, тамга тэмдэг үрэгдүүлсэн 2, шинээр аж ахуй нэгж байгуулах 35 шинээр эрх олгогдсон сумдын 97 нийт 172 бүртгэлд хяналт шалгалт хийж зөвлөгөө мэдээлэлээр хангаж ажиллаа.

2. Зөрчил шалган шийдвэрлэх болон хялбаршуулсан журмаар шийдсэн зөрчил

2025 оны жилийн эцсийн байдлаар хяналтын улсын байцаагчийн 60 ширхэг дүгнэлт гаргасан байх бөгөөд бүртгэл хүчингүй болгох 4, нөхөн цахимжуулах 2, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах 4, бүртгэлд засвар өөрчлөлт оруулах 2, гэрлэлт нөхөн бүртгэх 3, эрхийн улсын бүртгэл хаах 1, хаяж гээгдүүлснээс болж эрхийн улсын бүртгэл хүчингүй болгох 41 дүгнэлтийг гарган бүртгэл үнэн зөв байх зарчимыг баримтлан ажиллаж байна.

“Бүртгэлийн зөрчилөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудлууд” “Бүртгэлтэй холбоотой илэрч буй зөрчил анхаарах асуудлууд”сэдэвт 2 удаагын сургалтыг хэлтсийн төвийн албан хаагчидад танхимаар сумдын улсын бүртгэгч нарт цахимаар хийж мэдээ мэдээлэлээр хангаж ажиллаа.

Мөн хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн 232 зөрчил байх бөгөөд 5.850,000 / таван сая найман зуун тавин мянга / төгрөгийн мөнгөн торгуулийг улсын төсөвт төвлөрүүлээд байна.

Сумдын улсын бүртгэгч нарт иргэний үнэмлэхийн 18, 25, 45 насны сунгалт хийлгэж буй иргэдийг зөрчлийн хууль зөрчигдөхөөс сэргийлэн төлөвлөгөөг гаргуулан ажилласны үр дүнд өмнөх үеийн зөрчилөөс 120 зөрчилөөр багассан байна.

Мөн хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлийг хуулийн хугацаанд бүртгүүлэх, төрийн бус байгууллагын тайланг хуулийн хугацаанд хүлээн авах зэрэг ажлуудыг Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэгчтэй хамтран зохион байгуулж утсаар ярих болон цахим хэлбэрээр мэдээ мэдээлэлийг түгээн ажиллаа.

3. Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх.

Хэлтэс болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан сургалтуудад идвэхитэй суралцаж нийт 19 сургалтад хамрагдаад байна. Мөн удирдлагын академийн богино хугацааны сургалтад суухаар төлөвлөн Улсын бүртгэлийн ерөнхий газар санал хүсэлтээ хүргүүлээд байна. Мөн Монгол бичгийн үндэсний бодлогын хүрээнд Удирдлагын акедемийн бэлгэсэн цахим хичээлийг бие даан судлаа анхан болон дунд шатыг амжилттай суралцаж сертификатыг аваад байна.



4. Статистик болон зөрчлийн тоон мэдээ тайлагнах:

Сар бүрийн статистик тоон мэдээ болон зөрчлийн мэдээг zurchliin.san@burtgel.gov.mn хаягаар тогтоосон хугацаанд нийт 10 удаа хүргүүлээд байна. 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр хяналтын улсын байцаагчийн нийт 60 дүгнэлтийг гаргасан бөгөөд гаргасан бүх дүгнэлтийг хяналт шалгалт зөрчлийн нэдсэн санд бүртгэн нотлох баримтын хамт цахимжуулан ажиллаж байна.

5. Бусад

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Аргачлал загвар батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг үндэслэн “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан, арга хэмжээний шалгуур үзүүлэлт бүрийг тодорхой хугацаанд биелэгдэхээр төлөвлөн боловсруулж, тогтоосон хугацаанд тайлагнаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлэн ажиллаа.

Мөн Асгат, Дарьганга, Наран, Онгон сумдад зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож иргэд олон нийтэд бүргэлийн байгууллагын талаар мэдээ мэдээлэлийг өгч ажиллаа.

ЗУРГАА. АРХИВЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Иргэний улсын бүртгэлийн архивын чиглэлээр

2025 оны хагас жилийн байдлаар иргэний бүртгэлийн архивын санд 77023 хувийн хэрэг хадгалагдаж байна. Бусад аймаг нийслэлээс 200 иргэн, 150 хүүхдийн хувийн хэрэг болон биеийн давхцахгүй өгөгдлийн ИУБ-31 маягт 1200 ширхэгийг галиглан хувийн хэргийн санд байршуулсан.

ИУБ31 маягтын А талыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын иргэний бүртгэлийн асуудал хариуцсан нэгжид, иргэний үнэмлэхний хугацаа сунгалт ИУБ31 маягтын А талыг Улсын бүртгэлийн төв архивын Иргэний баримтын архивт нэрийн үсгийн эхээр галиглан, дагалдах хуудсын хамт хүргүүлж байна.

Архивын фондоос 100 иргэний хувийн хэрэг болон журнал,хаатр-1 маягт, хаатр-11, ИУБ-11 маягтуудыг татан авч шалгаж цахимжуулж зөрчлийг арилгасан байна.

Сар болгоны 25 өдрөөр тасалбар болгон мэдээ тайлангаа тогтмол гаргаж өгдөг.

Шинээр цахим үнэмлэх авах 2000, 1980, 2009 оны **550** ИУБ11 маягтуудыг программд шалгаж өөр аймаг, хотод ИШБ-д хамрагдсан **300** ИУБ11 маягтуудыг тухайн аймаг, хотод шилжүүлэв. Нөхөн бүртгэлээр **10** иргэний хувийн хэргийг /ИУБ11, ИУБ15/ маягтуудыг журнал хувийн хэргийн лавлагааг үндэслэн иргэний улсын бүртгэгчээр бүрдүүлэн хувийн хэрэгт байршуулсан.

Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгж буюу хуудас баримт бичгүүдийг хэлтсийн дэргэдэх комиссын хурлаар хэлэлцэж баталсан шийдвэрийн дагуу Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаал,Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025 оны 02 сарын 14-ны өдрийн А/03 тушаал, УБЕГ-ын даргын 2024 оны 12 сарын 18 өдрийн 9/16182 тоот зөвлөмж чиглэлээр салбарын үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа дууссан баримт бичгүүд болон бусад материалуудыг жагсаалт гарган УБЕГ-ын ББНШАЗК-хүргүүлж баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнтэй устгах ажлыг зохион



байгуулсан

Мөн 2025 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн архивын баримтуудаа тооллогод хамруулж дуусгасан байна. Үүнд.

- Архивын санд хадгалагдаж байгаа хувийн хэргийн тоо-77023
- Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэн (16, 25, 45 нас)-29775
- 16 наснаас доош насны хүүхдийн хувийн хэрэг (ИУБ-11 маягт)-29604

-Тодорхойгүй санд байгаа хувийн хэрэг-750,000

-Архивын санд хадгалагдаж байгаа нас баралт-11,188 хадгалагдаж байна.

Хуулийн этгээд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын чиглэлээр

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/290 тушаалын хавсралтын Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг архивт хадгалах журмын 4.5.1-нд заасны дагуу аймаг, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст бүртгэгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг болон улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг бүртгэл хийснээс хойш ажлын 1 өдөр, анхны бүртгэлийг ажлын 5 хоногийн дотор гэсэн журмыг үндэслэн улсын бүртгэгч нараас мэдүүлэг, нотлох баримт, анхны бүртгэлийг архивт хүлээн авч ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтсийн даргын тушаалыг үндэслэн хавсралтад заасан нэр бүхий хуулийн этгээдүүдийн хүчингүй болон 14 тамга тэмдэгийг хураан авч устгалд оруулаад байна.



Хураан авсан тэмдэгүүдийг устгал хийх явц

Эд хөрөнгө эрхийн бүртгэлийн архивын хувийн хэргийн нотлох баримт 17851, үүнээс газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн нотлох баримт 9012, гэр бүлийн зориулалтаар өмчилж буй газрын 8841, нотлох баримтууд Сүхбаатар аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн архивт байршиж байна. Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны баталгаажуулалт 228, төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэсэн 151 хувийн хэрэг шинээр нэмэгдсэн байна мөн шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэсэн хувийн хэрэг 72 байна. Эд хөрөнгийн архивын хуулбар 32, аж ахуй нэгжид олгосон хуулбар 29, хуулийн этгээдийн аж ахуй нэгжийн хувийн хэргийн тоо 2063, 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар аж ахуй нэгжийн хувийн хэргийн тоо 86-аар нэмэгдэж байна.

хувийн хэрэг, үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 114, шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэсэн хувийн хэрэг 72, газрын баяжилт 486, хувийн хэргийг эмхэлж архивт байрлуулав.

Улсын бүртгэгч нарын өдөр тутмын хөтөлсөн бүртгэлийн эх нотлох баримтыг журамд заасан хугацаанд хүлээн авч хувийн хэрэгт баяжилтыг хийж ажиллав

ДОЛОО. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тус хэлтэс нь 2025 оныг “Төрийн албан хаагчын ёс зүй, хариуцлага, нийгмийн баталгааг дээшлүүлэх жил болгон ажиллаж байна.

Эд хөрөнгө хуулийн этгээдийн тасаг нь 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 5589 мэдүүлэгийг хүлээн авч 22113 хуудасыг цахим санд цахимжуулаад байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр дараах үйлчилгээг үзүүллээ. Үүнд

- ✓ Шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх – 130
- ✓ Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх – 199
- ✓ Өмчлөх эрх шилжих гэрээ – 694
- ✓ Барьцааны гэрээг, барьцааны гэрээ дуусгавар болгох – 2944
- ✓ Түрээсийн гэрээ – 3
- ✓ Бүртгэлд өөрчлөлт оруулах – 229
- ✓ Лавлагаа хуулбар – 73
- ✓ Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх – 232
- ✓ Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцэлээр бүртгэл салгасанаар шинэ бүртгэл үүсгэх - 7 гэсэн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлээд байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнээс улс, орон нутгийн төсөвт татварын орлого 325,812,355 төгрөг, үйлчилгээний хөлс 83,259,876 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 6,129,433 төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

Мөн МИК-активаас барьцааны гэрээг дуусгавар болгох онлайн 151 ширхэг мэдүүлэгийг хүлээн авч шийдвэрлээд байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд санал хүргүүлсэн. Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн EPRS болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ERS цахим системд сайжруулалт хийх шаардлагатай тоон мэдээлэл буруу гардаг, цахимжуулалтын үед алдаа гардаг болон зураг хадгалахгүй байх зэрэг алдаануудыг саналыг тухай бүрт нь өгч ажиллаа.


 **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ДОТООД АЛБАН БИЧИГ**

2025.02.27 № 6 Улаанбаатар хот

Хаанаас: Тамгын газар
Хаана: Бүх газар, хэлтсийн дарга нарт

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/19 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах саналаа 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн дотор Тамгын газрын Эрх зүйн хэлтэс e.battsengel@burtgel.gov.mn-т ирүүлнэ үү.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  Д.ДАВААНЖАМ

Нийт Улсын бүртгэлийн болон ХЗБ-г
Дээрх хуулийн төсөлд туслах саналыг
2025.03.07-ны өдөр байгуулсан
цахим хэлтэст sukhbaatar@burtgel.gov.mn
халаар илгээх.
2025.02.27. 

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАХ
САНАЛ

..... аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс

Ид	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зүйл, заалт	Саналын тохжил	Саналын үндэслэл, тэмдэг	Бусад хууль тогтоомжтой зөрчил, давхардал бий эсэх
----	--	----------------	--------------------------	--

Жич: Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдэл түүнээс үүдэн гарсан бодит кейс, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх явцад тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагыг үндэслэн саналаа дээрх хүснэгтийн дагуу боловсруулж 2025 оны 3 дугаар сарын 18-ний өдрийн дотор e.olontungalag@burtgel.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр үйлчилгээний танхимаар 37 лавлагаа, харин хууль хяналтын байгууллагын албан бичгээр үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрх түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх болон бусад албан бичиг нийт 114 бүртгэл хөтөлж хариу албан бичгийг холбогдох лавлагаа, мэдээллийн хамт хууль, журмын дагуу олгоод байна.

Мөн хамрагдвал зохих танхимын болон цахим сургалтуудад идэвхитэй бүрэн хамрагдсан.

Хамтын ажиллагаа, бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах, төрийн үйлчилгээг иргэнд ойртуулах зорилгоор байгууллагуудтай хамтран дараахь арга хэмжээг шинээр санаачлан зохион байгууллаа. Үүнд:

1. Хариуцлагатай жижүүрээр ажиллав.

МУ-ын засгийн газрын 109 дүгээр тогтоолын дагуу Хэлтсийн даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/06 дугаар тушаалаар сар шинийн баярын өдрүүдийн амралтад зохицуулалт хийх хариуцлагатай жижүүрээр ХЭЭХЭУБ-ын тасгын 3 албан хаагч ажиллав.


Хариуцлагатай жижүүр томилогон ажиллуулах тухай		Угсар бүртгэлийн үйлчилгээний даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/06 дугаар тушаалын хавсралт			
Д/д	Өвөг нэр	Албан тушаал	Хариуцлагатай жижүүр ажиллах өдөр	Тасгийн цаг	Утасны дугаар
1	Ж.Должинсүрэн	Хуулийн этгээдийн үйлчилгээний даргын бүртгэл	2025.03.01	08.00-12.00	89778506
2	Г.Болор-Ордина	Бичиг хэрэг, ирвэл	2025.03.01	13.00-17.00	89228954
3	Г.Оюунжаргал	Хуулийн этгээдэд эд хөрөнгийн өөрчлөхийн үйлчилгээний даргын бүртгэл	2025.03.02	08.00-12.00	95048666
4	Д.Сайнбаяр	Иргэний бүртгэлийн тасгийн дарга, бичигд үйлчилгээний бүртгэл	2025.03.02	13.00-17.00	89778901
5	С.Дорногойма	Бичиг хэрэг, ирвэл	2025.03.03	08.00-12.00	89119445
6	Ц.Алтанцэцэг	Иргэний бүртгэлийн тасгийн дарга, бичигд үйлчилгээний бүртгэл	2025.03.03	13.00-17.00	95036210
7	Б.Алтанзуул	Бичиг хэрэг, ирвэл	2025.03.04	08.00-12.00	89775769
8	Б.Одонзүл	Хуулийн этгээдийн үйлчилгээний даргын бүртгэл	2025.03.04	13.00-17.00	95850006
9	А.Одбаяр	Мэдээлэл, танилцуулга, хэвлэл	2025.03.05	08.00-12.00	89022427
10	С.Энхбаяр	Хуулийн этгээдэд эд хөрөнгийн өөрчлөхийн үйлчилгээний даргын бүртгэл	2025.03.05	13.00-17.00	89051736

Зураг

2. Хуульчийн Про Боно өдөр-2025” өдөрлөгт оролцов.

Монголын Хуульчдын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготой хууль зүйн үнэнгүй зөвлөгөө өгөх “Хуульчийн Про Боно өдөр-2025” өдөрлөгт Улсын бүртгэлийн хэлтэс оролцож

- ✓ Иргэний улсын бүртгэл - 31
- ✓ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл - 36
- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэл -27 иргэнд өөрийн байгууллагыг сурталчилан таниулж ажиллаа. Өдөрлөгийн хүрээнд 6 иргэнд тоон гарын үсгийг олгосон байна.



3. Авилгын эсрэг аянд нэгдэв.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хүрээнд авилга ашиг сонирхолоос ангид байж шудрага ёсыг эрхэмлэх хүрээнд Сүхбаатар аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжилтийг ханган ажиллаа



4. Нээлтэй хаалганы өдрийг зохион байгуулав.

Иргэдэд бүртгэлийн үйл ажиллагааг түргэн шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор Асгат, Дарьганга, Онгон, Наран, Баяндэлгэр, Уулбаян, Түвшинширээ, Мөнххаан, Түмэнцогт, Халзан зэрэг сумдад нээлтэй хаалганы өдрийг зохион байгуулж ажилласан бөгөөд тус ажлын хүрээнд эд хөрөнгийн хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 202 иргэн аж ахуй нэгжид бүртгэлийн үйлчилгээг хүргэсэн байх бөгөөд 774 иргэн болон аж ахуй нэгжид зөвлөгөө мэдээлэлийг өгч ажиллаа

Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх талаар заавар зөвлөгөөг сумдын улсын бүртгэгч нарт өгч ажиллаа.



!!! LTE



Q.



1 comment



Admin 1 Oct · 🌐

...

УПСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНӨЙ ГАЗАР
ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УПСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

УСТАВНОЕ СООБЩЕНИЕ
ОТЧЕТЫ

[illegible]

3. *La prima delle seguenti affermazioni è vera, la seconda è falsa.*

1. Identify the main purpose of the document.	2. Identify the main purpose of the document.
3. Identify the main purpose of the document.	4. Identify the main purpose of the document.

[illegible]

www.burleigh.com.au 1800-0960 7094 3226 7094 8706




3 shares

НАЙМ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР


2025 оны 01.01.-2025.11.11.ны хоорондох хугацаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр дараах бүртгэлүүдийг хийж гүйцэтгэсэн.

Шинээр бүртгүүлсэн хуулийн этгээд 2025.11.11.ны байдлаар



2025.11.11-ний өдрийн байдлаар иргэн, хуулийн этгээдээс нийт-354 материал хүлээн авч шийдвэрлэн 347 олголт хийсэн. Татан буугдсан хуулийн этгээд-7, Үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн - 35, Салбарын бүртгэл-10, Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт-209, Хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын хуудсыг шинээр болон дахин олгосон - 216, Хуулийн этгээдийн бүртгэлд хориг цуцласан бүртгэл - 2, хориг сэргээсэн бүртгэл -1 Лавлагаа - 47, Хуулбар – 25, Шинээр оноосон нэрийн 126 хүсэлтийг тус тус бүртгэгдсэн байна.

Тус аймагт анх удаа дундын хоршооны бүртгэл хийгдсэн.



Төрийн бус байгууллагууд 2024 оны үйл ажиллагааны тайлангаа 02 сарын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэх хуулийн хүрээнд сумын бүртгэгч нартай хамтран 69 хуулийн этгээдийн тайланг авч архивлан хүлээлгэн өгсөн.

Оноосон нэрийг цахимаар олгох үйлчилгээг E-business.mn портал төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системээр ирсэн 1464 нэрийг шүүж хариуг цахимаар хүргүүлэн татгалзсан нэрийн мэдээг 7 хоног бүр улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж байна.

Тус аймгийн Онгон суманд нээлттэй хаалганы өдөрлөгийг 2025.02.06-02.07.өдрүүдэд иргэний улсын бүртгэгч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч, ахлах бүртгэгч нарын хамт зохион байгуулж хуулийн этгээдийн 7 хүсэлт гаргасан иргэдийн бүртгэлийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Хэлтсийн даргын 2025 оны 04.15-ны А/07 тоот тушаалаар Мөнххаан,Түмэнцогт суманд нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулах ажлын хэсэгт томилогдсон ажилласан. Хуулийн этгээдийн 11 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.Мэдээлэлд оруулсан өөрчлөлт хөрөнгийн өөрчлөлтийн бүртгэлийг 10 хуулийн этгээдийн бүртгэл, 1 тэмдэг шаардлага хангахгүй хүчингүй болгож хяналтын хуудсыг олгосон. Нотлох баримтын шаардлага хангаагүй болон баримт бичгийн бүрдэл дутуу 25 иргэнд зөвлөмж мэдээллийг хүргэж ажилласан.



Алслагдсан 7 сумын эрх зүйч мэргэжилтэй улсын бүртгэгч мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч 1 хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон зай цаг хугацаа, төсөв хөрөнгийг хэмнэсэн үйлчилгээг үзүүлж байна.

Улсын бүртгэгч нарын бүртгэлийн тоон үзүүлэлт



Хуулийн этгээдийн бүртгэл хөтөлж байгаа сумдын улсын бүртгэгч нарт утсаар болон ажлын байрны дадлага сургалт заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

ЕС. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Сүхбаатар аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 2025 оны мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд гэрлэлт, төрөлт, нас баралтын зэрэг бүртгэлийн бүртгэсэн огноо зөрүүтэй 2142 иргэний мэдээллийн сангийн алдааг тус тус засах ажил хийж гүйцэтгээд байна.

2025 оны байдлаар 16-с ба түүнээс дээш насны 43281 иргэн байгаагаас 25106 иргэнд тоон гарын үсэг олгож нийт иргэдийн 58,0 хувь нь хамрагаад байгаа болно.



Иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч нарт мэдээллийн сангийн засвар өөрчлөлтийн эрх олгосноор Төрсний бүртгэлд нэмэлт өөрчлөлт 237, гэрлэсний бүртгэлд нэмэлт өөрчлөлт 3, нас барсны бүртгэлд нэмэлт өөрчлөлт 2, төрсний нөхөн бүртгэл 14, гэрлэсний нөхөн бүртгэл 25-г бүртгэсэн байна.

Иргэний улсын бүртгэлийн газраас нийт 17 удаагийн иргэний улсын бүртгэлтэй холбоотой зөвлөмж чиглэл ирсэнийг хэлтсийн болон сумдын бүртгэгч нарт дотоод группээр дамжуулан түргэн шуурхай хүргэж, ажилдаа мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа сар бүрийн 27-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн УБЕГ-ын Улсын бүртгэгч Ж.Нарантуяад j.narantuya@burtgel.gov.mn хаягаар, иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааны мэдээг сар бүрийн 26-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын мэдээг нэгтгэн Иргэний бүртгэлийн нэгдсэн архивын ахлах мэргэжилтэн Я.Мөнхтулга ya.munkhtulga@burtgel.gov.mn хаягаар мөн Иргэний бүртгэлийн тасгийн сар бүрийн тайланг p.enkhnar@burtgel.gov.mn хаягаар тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хүрээнд иргэний бүртгэлийн чиглэлээр тоон мэдээг аймгийн хэмжээнд нэгтгэвэл:

✚ Төрсний бүртгэл 789

- ✚ Гэрлсний бүртгэл 124
- ✚ Гэрлэлт дуусгавар болсоны бүртгэл 38
- ✚ Монгол улсын иргэнд хүүхэд үрчлэлтийн бүртгэл 5
- ✚ Эцэг тогтоолтын бүртгэл 34
- ✚ Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрээ сольсоны бүртгэл 27
- ✚ Нас барсны бүртгэл 319
- ✚ 16 нас хүрч иргэний үнэмлэхийн бүртгэл 923
- ✚ Иргэний үнэмлэх дахин олголт 488
- ✚ Иргэний үнэмлэхний 25,45 насны сунгалт 1241
- ✚ Үндэсний энгийн гадаад паспорт захиалга 3585
- ✚ БНХАУ-д зорчих нэг удаагийн үнэмлэх олголт 11
- ✚ БНХАУ-д зорчих олон удаагийн үнэмлэх олголт 239
- ✚ Аймаг хотоос шилжин ирсэн 546
- ✚ Регистрийн дугаарын өөрчлөлтийн бүртгэл 4
- ✚ Аймаг доторх шилжилт хөдөлгөөн 1028

Иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааг нэгтгэвэл :

- ✚ Албан хэрэгцээнд 2008
- ✚ Хууль хяналтын байгууллагад 241
- ✚ Иргэнд 3965
- ✚ Төрийн болон төрийн бусад байгууллагад өгсөн лавлагаа 0

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хагас жилийн байдлаар 4502 бүртгэлийн 10352 хуудас бүхий нотлох баримт цахимжаад байна. Үүнээс төрсний бүртгэл 1497, иргэний үнэмлэхний иуб-31 бүртгэл 2380, гадаад паспорт 1833 бүртгэлүүд дийлэнх цахимжуулалтыг эзлэж байна.

Гадаад паспортын бүртгэл хөтлөх ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээг зохион байгуулж, сумдын улсын бүртгэгч нарт гадаад паспортын бүртгэл хөтлөх эрхийг олгож, улмаар ажлын байрны сургалтыг өгч дадлагажуулснаар нийт бүртгэл хөтлөгдсөн байна. Энэ хэмжээгээр аймгийн төв дээр хийгдэх тухайн бүртгэлийн ачаалал багассан. Энэ нь иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, тэдний цаг хугацаа, зардалыг хэмнэсэн үр ашигтай арга хэмжээ болсон.

2025 оны 10 дугаар сарын 06 ны өдрөөс 10 дугаар сарын 10 ны өдрийн хооронд тус аймгийн Түвшинширээ, Уулбаян, Мөнххаан, Түмэнцогт сумдад ажиллаж, 145 иргэнд гадаад паспортын захиалга авч, хурууны хээ танихгүй өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэнд регистрийн дугаараар тоон гарын үсэг олгосон.



Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгийн Хүүхэд гэр бүл хөгжлийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран 8 хосд гэрлэлтийн гэрчилгээ гардуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллаа.

Мөн энэ онд байнгийн хэвтэрт асаргаанд байдаг 8 иргэнд зөөврийн төхөөрөмжөөр гэрт нь очиж улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэв.



Сүхбаатар аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хоригдож буй иргэний гэрлэлтийн бүртгэлийг бүртгэсэн.

Иргэний үнэмлэхний зураг засвараар нийт 2550 иргэний зургийг зассан.

АРАВ. САНХҮҮ БҮРТГЭЛ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭЭР

1.Төсөв:

2025 оны 4 дугаар улирлын 11 дүгээр сарын байдлаар төсвийн санхүүжилтээр 1,028,7 сая төгрөгөөр бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад албан хаагчдын цалин нэмэгдэл, хоол унааны зардалд 843,1 сая төгрөгийг, НДШ-ийн зардалд 114,9 сая төгрөг, Байр ашиглалтын зардалд 23,5 сая төгрөг, Хангамж бараа материалын зардалд 16,3 сая төгрөг, Бусад зардалд 8,0 сая төгрөгийг зарцуулсан байна.

2025 оны арван нэгдүгээр сарын байдлаар 23,8 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа бөгөөд. Тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд Албан хаагчдын нэмэгдэл болох 33,6 сая төгрөг АЗДТГазраас Орон нутгийн нэмэгдэл төсөв орж ирсэн 33,0 сая төгрөгийн зардал гарсан байна. 2025 оны 06 дугаар сард Сүхбаатар аймгийн Халзан, Уулбаян сумдад сумын ИТХ-ын нөхөн сонгууль болж УБЕГазраас нөхөн сонгуультай холбоотой 2,3 сая төгрөг орж ирж зориулалтын дагуу зарцуулсан болно.

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар тус хэлтэс нь улсын төсөвт аймгийн 65 мянган иргэдэд үйлчилсэн бүртгэлийн үйл ажиллагаанаас олсон 88,2 сая төгрөг орсоноос 86,4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан байна. Үлдэгдэл 1,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны өдрийн дотор нэгтгэн гаргаж УБЕГазрын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. 13 сум болон аймгийн төвийн улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайлан, орлогын мэдээг сар бүрийн 25-наар тасалбар болгон авч нэгтгэн гаргаж тайлан мэдээг дараа сарын 05-ны дотор УБЕГазрын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Ажилтан албан хаагчдын НДШимтгэл төлөлтийн тайланг сар бүрийн 05-ны өдрийн дотор Аймгийн НДГазартай тооцоо нийлж баталгаажуулдаг. ХАОАТатварын тайланг улирал бүр аймгийн Татварын газартай тооцоо нийлж байна.

2. Санхүү, Аудитын чиглэлээр

2024 оны санхүүгийн аудитаар Аймгийн Төрийн аудитын байгууллагаар Түүвэрт хамрагдаж санхүүгийн үйл ажиллагааг шалгуулж бүртгэл санхүүгийн зөрчилгүй ажилласан байна.

Мөн төрийн аудитын байгууллагын албан хаагчдаас заавар зөвлөгөөг авч өөрийн ажлын үр дүнг ханган ажиллаж байна.

Өмнөх оны Төрийн аудитын байгууллагын зөвлөмжийг 100% хуулийн хугацаанд хийж гүйцэтгэсэн байна гэж дүгнэсэн болно.

3.Шилэн данс

2025 онд Улсын бүртгэлийн хэлтэс нь МУ-ын шилэн дансны нэгдсэн сайтад 171мэдээлэлийг байршуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Үүнээс 146 мэдээлэлийг хуулийн хугацаанд үнэн зөв, Урсгал санхүүжилтийн нийт 1.028.7 сая төгрөгийг шилэн дансны сайтад байршуулан ажилласан байна.

Мэдээлэлийг хуулийн хугацаанд , шаардлага хангасан мэдээлэлийг цаг алдалгүй тухай бүр байршуулж хэвшсэн байна.

2025 оны 11-р сарын 09-ны байдлаар нийт 146 мэдээлэл байршуулах ёстой бүх мэдээлэлийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулан ажилласан байна. Хугацаа хоцорсон болон байршуулаагүй мэдээлэл байхгүй болно.

2025 оны шилэн дансны мэдээлэлийг 100% байршуулан ажиллах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

2024 онд УБХэлтэс нь шилэн дансны мэдээлэлийг 100% байршуулан ажиллсан.

4.Хүний нөөцийн чиглэлээр

Тухайн онд зэрэг дэвийн нэмэгдэл, Унаа хоолны нэмэгдэлийг УБЕГазраас шийдвэр гарсан дариуд системд оруулан албан хаагчдын нэмэгдлийг боддог. Аймгаас Орон нутгийн нэмэгдэл сар бүр 10% эдгээр нэмэгдлийг цаг тухай бүр нь хүний нөөцийн системд улиралд 30% иар тооцож ажилтан албан хаагч бүрт олгож байна.

Хэлтсийн даргын тушаалаар 2025 оны хагас болон 3 дугаар улирлын албан хаагчдын үр дүнгийн урамшуулалыг тооцож олгосон байна.

2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар тус хэлтэс нь 27 ажилтан албан хаагчийн орон тоотой ажиллаж байгаагаас ТЗ-ын 20, ТҮМ-ийн 4, Гэрээт 3 ажиллаж байна. ТАЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын “ 1 дүгээр хавсралт” Төрийн албан хаагчийн хувийн хэргийг хөтлөх журмын дагуу албан хаагчидын хүн тус бүрийн хувийн хэргийн бүрдлийг хангаж , ТАЗ-ийн хүний нөөцийн удирдлагын системд албан хаагч бүр өөрсдийн мэдээлэлийг тулган баталгаажуулсан болно. Албан хаагчдын алдаатай мэдээлэлийг тухай бүр засаж залруулсан.

МУЗГ-ын тогтоолоор үндсэн цалингийн шинэчлэлтийг хийсэн. Таван жилийн тэтгэмж урамшуулалттай холбоотой албан хаагчдын нийт ажиллсан жил болон бусад мэдээлэлийг нарийн судалж хүний нөөцийн системд оруулаад байна.

АРВАН НЭГ. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

1.Техник, программ хангамж


Ажилтан албан хаагчийн ашиглаж буй компьютерт нийт 104 удаа хэрэглээний болон мэргэжлийн программ хангамж суулгаж принтер, компьютер болон бусад тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг 23 удаа хийж техник хэрэгсэлийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллаж байна.

2.Сүлжээ-Дотоод сүлжээ

Дотоод сүлжээ болон сүлжээний аюулгүй байдлыг хянах зорилгоор дотоод сүлжээг шаардлагатай байрлалаар зохион байгуулж сүлжээний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Мөн гадаад сүлжээний аюулгүй байдлыг хангах хүрээнд сүлжээний кабель тоног төхөөрөмжийг цэцгцлэн, интернетийн сүлжээний зураглал гарган хаягжуулсан.

Сүхбаатар аймгийн 13 сум, хэлтсийн хэмжээнд бүртгэлийн ерөнхий сүлжээ нь Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ын сүлжээгээр хангагдаж ажиллагаа бүрэн хэвийн ажиллаж байна.

Хэлтсийн байрны болон Сүхбаатар сумын дотоод сүлжээний рүүтер төхөөрөмж гэмтэж шатсаныг шинээр сольж хэвийн ажиллагааг хангасан.



3.Мэдээ мэдээллийн ил тод байдал

Иргэд олон нийтэд хэлтсийн үйл ажиллагаа мэдээ мэдээлэлийг хүргэх, өөрийн байгууллагаа сурталчилан таниулах, мэдээлэлийг хүртээмжтэй нээлттэй ил тод байлгах үүднээс

- ✓ Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс www.sukhbaatar.burtgel.gov.mn
- ✓ Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс www.gov.mn/mn/organization/sukhubh
- ✓ Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс www.facebook.com/sukhbaatarburtgel

Зэрэг мэдээлэлийн сувгуудаар мэдээ мэдээлэлийг түгээн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 74 мэдээ мэдээлэл бэлтгэн вэб сайт болон фэйсбүүк цахим хуудсаар мэдээлсэн.

Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган санхүүгийн тайлан, ажлын байрны шинэ зар, жил улирлын тайлан, статистик тоон мэдээ, өргөдөл гомдлын мэдээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээ зэргийг сар бүрээр тогмол вэб сайт болон фэйсбүүк фэйжид байршуулж байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын фэйсбүүк хуудсаар оруулсан нийт 98 мэдээ мэдээллийг өөрийн фэйсбүүк хуудсаар дамжуулан дахин шэйрлэж түгээсэн.


Төрийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байлгах, олон нийтийн хяналтыг бий болгох зорилготой нээлттэй мэдээллийн систем www.shilen.gov.mn тайлан мэдээ мэдээллийг цаг тутам байршуулан дүгнүүлж

- ✓ 1-р улирал – 99,9%
- ✓ 2-р улирал – 100%
- ✓ 3-р улирал – 100%-ийн гүйцэтгэлтэйгээр үнэлүүлэн ажиллаж байна.


#	Тайлант үе	Хувиолбар	Төлөв	Төлөвийн огноо	Илгээсэн хэрэглэгч	Баталгаажсан үнэлгээний хувь	Баталсан мэргэжилтэн	Үйлдэл
1	2025 оны 4 улирал (2025-4)	1	Баталсан	2025-11-07		0%		+ Бөглөх
2	2025 оны 3 улирал	1	Баталгаажсан	2025-09-26	odbayar@burtgel.gov.mn	100%	3.0/ЮУН-ЭРДЭНЭ	
3	2025 оны 2 улирал	1	Баталгаажсан	2025-08-13	odbayar@burtgel.gov.mn	100%	3.0/ЮУН-ЭРДЭНЭ	
4	2025 оны 1 улирал	1	Баталгаажсан	2025-03-22	odbayar@burtgel.gov.mn	99.9%	3.0/ЮУН-ЭРДЭНЭ	

5. Бусад

Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Миний бахархал-Миний мэргэжил” сэдвийн хүрээнд 2 ширхэг цахим контент бүтээж Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудас болон бусад мэдээлэлийн сувгуудаар түгээн ажиллаа.



СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН БРЭНДБҮҮК ТУГ




НЭРИЙН ХУУДАС



АЖЛЫН ҮНЭМЛЭХ






МЭДЭЭЛЛИЙН САМБАР



ХАНЫН ХАЯГ







ГАДНА ХАЯГЖИЛТ


ᠠᠨᠠᠭ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ	
СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС	
101	УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН АРХИВ
201	ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ
201	ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ
202	ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
202	ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ
203	АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ
205	ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ
206	АРХИВ БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ, НЯРАВ
207	ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ
208	ХЭЛТСИЙН ДАРГА



ДОТОР ХАЯГЖИЛТ& СТИКЕР







ТАТ ТҮЛХ НААЛТ

